



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН  
2024 ОНЫ НАМРЫН ЭЭЛЖИТ ЧУУЛГАН

2024 ОНЫ 12 ДУГААР САРЫН 20-НЫ ӨДӨР, БААСАН ГАРАГ

ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ

НЭГДСЭН ХУРАЛДААН



ХУРАЛДААН ЗОХИОН БАЙГУУЛАХ ХЭЛТЭС

Та хуралдааны тэмдэглэлийн цахим хувьтай дараах  
QR кодыг уншуулан танилцах боломжтой.

**НЭГДСЭН ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН АГУУЛГА**  
**2024 оны 12 дугаар сарын 20-ны өдөр, Баасан гараг**

*Хуралдааны тэмдэглэлийн агуулга* 1

*Хуралдааны товч тэмдэглэл:* 2-3

*Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл:* 4-12

- 
- 1. Монгол Улсын Ерөнхийлөгчийн бүхэлд нь тавсан хоригийг хүлээн авч хууль, тогтоол хүчингүй болсонтой холбогдуулан Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуулийн төслийг хэлэлцэх дэгийн тухай хуулийн төсөл** 4-12

**Монгол Улсын Их Хурлын 2024 оны намрын ээлжит чуулганы  
12 дугаар сарын 20-ны өдөр /Баасан гараг/-ийн  
нэгдсэн хуралдааны товч тэмдэглэл**

Улсын Их Хурлын дарга Д.Амарбаясгалан ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 126 гишүүнээс 67 гишүүн хүрэлцэн ирж, 53.2 хувийн ирцтэйгээр хуралдаан 10 цаг 03 минутад Төрийн ордны “Их хуралдай” танхимд эхлэв.

Томилолттой: С.Амарсайхан, Д.Батлут, О.Батнайрамдал, Х.Булгантуяа, С.Бямбацогт, Г.Дамдинням, Ц.Мөнхбат, Н.Наранбаатар, Д.Рэгдэл, Ц.Туваан, Ж.Энхбаяр, Д.Энхтуяа, Р.Эрдэнэбүрэн;

Чөлөөтэй: Л.Оюун-Эрдэнэ, Д.Пүрэвдаваа, Б.Тулга;

Эмнэлгийн чөлөөтэй: Т.Аубакир, Д.Ганбат, З.Мэндсайхан, А.Ундраа, Ж.Чинбүрэн;

Тасалсан: Х.Баттулга, Ж.Ганбаатар, Б.Жавхлан, Б.Жаргалан, С.Лүндэг, Н.Учрал, Да.Цогтбаатар, Б.Энхбаяр;

Хоцорсон: Ц.Баатархүү-01 минут, Б.Батбаатар-18 минут, Д.Батбаяр-02 минут, Ж.Батсуурь-01 минут, Б.Батцэцэг-01 минут, Л.Гантөмөр-01 минут, Т.Доржханд-01 минут, Б.Заяабал-01 минут, Т.Мөнхсайхан-02 минут, Ц.Мөнхтуяа-25 минут, П.Наранбаяр-01 минут, М.Нарантуяа-Нара-02 минут, Ч.Номин-01 минут, Э.Обдаяр-01 минут, С.Одонтуяа-08 минут, Б.Пунсалмаа-19 минут, Х.Тэмүүжин-12 минут, Г.Тэмүүлэн-04 минут, Ч.Ундрям-02 минут, Д.Цогтбаатар-09 минут, Б.Чойжилсүрэн-02 минут.

**Нэг.Шүүхийн ерөнхий зөвлөлийн шүүгч бус гишүүнд нэр дэвшигчийг томилох тухай**

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Шүүхийн ерөнхий зөвлөлийн шүүгч бус гишүүнд нэр дэвшигч С.Энхбаатар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга Ч.Ариунхур, мөн газрын Хуулийн газрын дарга Ч.Дондогмаа, Байнгын хороодын ажлын албаны Хууль зүйн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Г.Золжаргал, ахлах мэргэжилтэн Б.Галсанбат нар байлцав.

Нэр дэвшүүлэх асуудлыг хэлэлцсэн талаарх Хууль зүйн байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Ц.Сандаг-Очир танилцуулав.

Нэр дэвшигчээс болон Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн С.Эрдэнэболд, Х.Баасанжаргал, А.Ганбаатар, С.Замира нарын тавьсан асуултад нэр дэвшигч С.Энхбаатар, ажлын хэсгийн ахлагч, Улсын Их Хурлын гишүүн Ц.Сандаг-Очир нар хариулж, тайлбар хийв.

**Д.Амарбаясгалан:** Байнгын хорооны саналаар Самдангийн Энхбаатарыг Шүүхийн ерөнхий зөвлөлийн шүүгч бус гишүүнээр томилохыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Татгалзсан: 26  
Бүгд: 97  
73.2 хувийн саналаар дэмжигдлээ.

Хуралдаанд оролцсон гишүүдийн олонх нь Самдангийн Энхбаатарыг Шүүхийн ерөнхий зөвлөлийн шүүгч бус гишүүнээр томилохыг дэмжсэн тул “Шүүхийн ерөнхий зөвлөлийн шүүгч бус гишүүнээр томилох тухай” Улсын Их Хурлын тогтоолыг баталсанд тооцов.

Улсын Их Хурлын дарга Д.Амарбаясгалан “Шүүхийн ерөнхий зөвлөлийн шүүгч бус гишүүнээр томилох тухай” Улсын Их Хурлын тогтоолын эцсийн найруулгыг танилцуулав. Эцсийн найруулгатай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно. Улсын Их Хурлын гишүүд тогтоолын эцсийн найруулгатай танилцлаа. /10:32/

Уг асуудлыг 10 цаг 32 минутад хэлэлцэж дуусав.

Чуулганы нэгдсэн хуралдаанаар 1 асуудал хэлэлцэв.

Чуулганы нэгдсэн хуралдааны зохион байгуулалтыг Улсын Их Хурлын Тамгын газрын Хуулийн газрын Хуралдаан зохион байгуулах хэлтсийн дарга Н.Наранцогт, шинжээч Ш.Мөнхцоож, С.Энхзаяа, ахлах мэргэжилтэн С.Золжаргал нар хариуцан ажиллав.

Хуралдаан 30 минут үргэлжилж, 126 гишүүнээс 97 гишүүн хүрэлцэн ирж, 76.9 хувийн ирцтэйгээр 10 цаг 33 минутад өндөрлөв.

**Тэмдэглэлтэй танилцсан:**  
ЕРӨНХИЙ НАРИЙН  
БИЧГИЙН ДАРГА

Б.БААСАНДОРЖ

**Тэмдэглэл хөтөлсөн:**  
ХУРАЛДААН ЗОХИОН  
БАЙГУУЛАХ ХЭЛТСИЙН  
ШИНЖЭЭЧ

Э.СУВД-ЭРДЭНЭ

## МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ

2024 оны 12 дугаар сарын 20-ны өдөр, баасан гараг  
Төрийн ордон “Их хуралдай” танхим  
10 цаг 03 минут.

### НЭГДСЭН ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ

**Д.Амарбаясгалан:** Улсын Их Хурлын гишүүдийн энэ өдрийн амгаланг айлтгая.  
67 гишүүн буюу 53,2 хувьтай ирц бүрдсэн тул өнөөдрийн чуулганы нэгдсэн хуралдаан эхэлснийг мэдэгдье.

Чуулганы нэгдсэн хуралдаанаар өнөөдөр 1 асуудлыг хэлэлцэнэ.

**Шүүхийн ерөнхий зөвлөлийн шүүгч бус гишүүнийг томилох тухай асуудал орж байна. Хэлэлцэх асуудалдаа оръё.**

Шүүхийн ерөнхий зөвлөлийн шүүгч бус гишүүнийг томилох тухай асуудлын Хууль зүйн байнгын хорооны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Цэндийн Сандаг-Очир танилцуулна. Индэрт урьж байна.

**Ц.Сандаг-Очир:** Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын шүүхийн тухай хуульд Шүүхийн ерөнхий зөвлөлийн шүүгч бус гишүүнийг Улсын Их Хурал нээлттэйгээр нэр дэвшүүлж, сонгон шалгаруулсны үндсэн дээр нэр дэвшигчийн сонсгол хийж, томилохоор заасан.

Монгол Улсын шүүхийн тухай хуульд Шүүхийн ерөнхий зөвлөлийн шүүгч бус гишүүний сонгон шалгаруулалтыг нээлттэй, ил тод, хараат бусаар зохион байгуулах үүрэг бүхий ажлын хэсгийг олон талын тэнцвэртэй төлөөллийн үндсэн дээр байгуулна гэж заасны дагуу Улсын Их Хурлын гишүүн Ц.Сандаг-Очир ахалж, Улсын Их Хурал дахь Монгол Ардын намын бүлгийн ажлын албаны дэд дарга О.Бат-Эрдэнэ, Улсын Их Хурал дахь Ардчилсан намын бүлгийн Хүний эрх, эрх зүйн бодлогын зөвлөх Номингэрэл, Ерөнхийлөгчийн Тамгын газрын Хуулийн бодлогын газрын дарга Мөнхболд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дэд дарга Батцэцэг, Хүний эрхийн Үндэсний Комиссын гишүүн Дондов, Монголын хуульчдын холбооны зөвлөлийн гишүүн Ц.Мөнхбат, Монголын өмгөөлөгчдийн холбооны удирдах зөвлөлийн гишүүн З.Сүхбаатар, Хууль зүйн үндэсний хүрээлэнгийн захирал Х.Эрдэм-Үндрэх, Монгол Улсын Их сургуулийн Хууль зүйн сургуулийн захирал Б.Амарсанаа, Отгонтэнгэр Их сургуулийн ахлах багш С.Эрдэнэболовор нарын бүрэлдэхүүнтэй байгуулсан болно.

Ажлын хэсэг Монгол Улсын шүүхийн тухай хууль, Шүүхийн ерөнхий зөвлөлийн болон Шүүхийн сахилгын хорооны шүүгч бус гишүүнийг сонгон шалгаруулах журмын дагуу сонгон шалгаруулалтын зарыг нийтэд мэдээлэх, нэр дэвших тухай хүсэлт, материал хүлээн авах, ажлын хэсэг байгуулах, нэр дэвшигчээр бүртгэж нийтэд мэдээлэх, нэр дэвшигчийн баримт бичгийг parliament.mn цахим хуудсанд байршуулах, нэр дэвшигчийн талаар мэдээлэл цуглуулах, шинжлэн судлах, нэр дэвшигч тус бүртээ ажлын хэсгийн ярилцлага зохион байгуулах, нэр дэвшигчийн сонсгол зохион байгуулах, сонсголын тайлан гаргах, нэр дэвшигчийг тодруулан

Улсын Их Хуралд санал болгох гэсэн тодорхой үе шатын хүрээнд сонгон шалгаруулалтыг олон нийтэд нээлттэй, ил тод зохион байгууллаа.

Шүүхийн ерөнхий зөвлөлийн шүүгч бус гишүүний сонгон шалгаруулалтын зарыг олон нийтэд нээлттэй, ил тод, хүртээмжтэй байдлаар мэдээлэн хүсэлт, материалыг 2024 оны 10 дугаар сарын 2-ны өдрөөс 10 дугаар сарын 23-ны өдрийг хүртэл 21 хоногийн хугацаанд хүлээн авсан бөгөөд тус хугацаанд 2 хүн материалыаа ирүүлсэн.

Ажлын хэсэг хүсэлт, материалыг хүн тус бүрээр хэлэлцэн хууль тогтоомжид заасан шаардлага хангасан гэж үзэн тус 2 хүнийг сонгон шалгаруулалтын оролцогчоор бүртгэсэн шийдвэрийг гаргасан болно.

Сонгон шалгаруулалтад 2 нэр дэвшигч оролцсон бөгөөд Монгол Улсын шүүхийн тухай хуульд заасны дагуу санал хураалтын дүнгээр ажлын хэсгийн гишүүдийн олонхын санал авсан нэр дэвшигчийг саналын дарааллаар эрэмбэлэн сул орон тоогоор болон дараагийн олонхын санал авсан хүний хамт нэр дэвшүүлж, Байнгын хороонд хүргүүлэх заалтын дагуу нэр дэвшигч Самдангийн Энхбаатар, Машлайн Алтан-Очир нарыг Шүүхийн ерөнхий зөвлөлийн шүүгч бус гишүүнд нэр дэвшүүлэн Хууль зүйн байнгын хороонд танилцуулсан болно.

Хууль зүйн байнгын хороо Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хууль, Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хууль, Монгол Улсын шүүхийн тухай хууль, Нийтийн сонсголын тухай хууль, Шүүхийн ерөнхий зөвлөлийн болон Шүүхийн сахилгын хорооны шүүгч бус гишүүнийг сонгон шалгаруулах журамд заасны дагуу нэр дэвшигчийн сонсголыг 2024 оны 12 дугаар сарын 11-ний өдөр зохион байгуулсан болно.

Хууль зүйн байнгын хороо 2024 оны 12 дугаар сарын 18-ны өдрийн хуралдаанаараа нэр дэвшигчийн сонсголын тайлан болон Шүүхийн ерөнхий зөвлөлийн шүүгч бус гишүүнд нэр дэвшүүлэх асуудлыг Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 108 дугаар зүйлд заасны дагуу хэлэлцлээ.

Байнгын хорооны хуралдаанаар тус асуудлыг хэлэлцэх үед Улсын Их Хурлын гишүүн С.Эрдэнэболд шүүх засаглалын бие даасан, шүүгчийн хараат бус байдлын талаар, Улсын Их Хурлын гишүүн М.Нарантуяа-Нара сонгон шалгаруулалтад цөөн хүн оролцсон талаар болон шинээр сонгогдох гишүүний хувьд анхаарах асуудлын талаар санал хэлсэн болно.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 108 дугаар зүйл, Монгол Улсын шүүхийн тухай хуулийн 77 дугаар зүйл, Хууль зүйн байнгын хорооны 2021 оны 6 дугаар тогтоолоор баталсан Шүүхийн ерөнхий зөвлөлийн болон Шүүхийн сахилгын хорооны шүүгч бус гишүүнийг сонгон шалгаруулах журмын 13 дугаар зүйлийн 13.5, 13.6 дахь хэсэгт заасны дагуу нэр дэвшигч тус бүрээр санал хураалт явуулсан бөгөөд нэр дэвшигч Самдангийн Энхбаатарыг Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжиж, Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд хэлэлцүүлж, Шүүхийн ерөнхий зөвлөлийн гишүүнээр томилуулах нь зүйтэй гэж үзсэн болно.

Шүүхийн ерөнхий зөвлөлийн шүүгч бус гишүүнд нэр дэвшигчийн танилцуулга, Шүүхийн ерөнхий зөвлөлийн шүүгч бус гишүүнээр томилох тухай Улсын Их Хурлын тогтоолын төсөл болон Байнгын хорооны санал, дүгнэлтийг гишүүд та бүхэнд тараасан болно.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Шүүхийн ерөнхий зөвлөлийн шүүгч бус гишүүнд нэр дэвшүүлэх асуудлыг хэлэлцсэн талаарх Хууль зүйн байнгын хорооны санал, дүгнэлтийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг та бүхнээс хүсье.

**Д.Амарбаясгалан:** Баярлалаа. Чуулганы нэгдсэн хуралдааны танхимд нэр дэвшигч Самдангийн Энхбаатар хүрэлцэн ирсэн байна.

Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан нэр дэвшигчээс асуулт асууж, үг хэлэх Улсын Их Хурлын гишүүд нэрээ өгье. Сүхбаатарын Эрдэнэболд гишүүн асуулт асууна.

**С.Эрдэнэболд:** Юуны өмнө Монгол Улсад шударга ёсыг бэхжүүлэх, шударга ёсонд итгэх, ялангуяа шүүхэд итгэх иргэдийн итгэл хөсөр унасан энэ цаг мөчид Шүүхийн ерөнхий зөвлөлийн шүүгч бус гишүүнд Хууль зүйн байнгын хорооноос дэмжлэг авч, Улсын Их Хурлын чуулганд бас танилцуулагдаж байгаа Энхбаатарт амжилт хүсье.

Тэгэхээр бас бид нар Байнгын хороо дээр сонсголын үеэр болон Байнгын хорооны хуралдаанууд дээр ярьсан. Иргэдийн зүгээс бол шүүхийн, шүүгчийн бие бие даасан байдал, хараат бус байдалд асар их эргэлзсэн ийм мэдээллүүд нийгэмд байгаа. Та Шүүхийн ерөнхий зөвлөлийн шүүгч бус гишүүнээр сонгогдон ажилласан тохиолдолд Их Хурлын гишүүдийн дэмжлэгийг авч өнөөдөр сонгогдсон тохиолдолд хамгийн түрүүнд ямар бодлогын шинжтэй ажлуудыг хийх вэ. Энэ нь яагаад ач холбогдолтой вэ, энэ талаараа та тодорхой байр сууриа илэрхийлнэ үү. Иргэдийн шүүхэд итгэх итгэл ганцхан л зүйл дээр тогтдог. Энэ бол шүүх өөрөө шударга бие даасан байх.

2 дугаарт түгээмэл иргэдийн дунд байдаг санал, шүүмж бол хонгил гэж яригддаг. Шударга бусын хонгил гэж яригддаг. Улс төрийн нөлөө бүхий хүмүүс шүүхэд хэрэг захиалдаг, хэн нэгнийг хэрэгтэн мэтээр хэвлэлээр цоллоод араас нь түүнд нь тохирсон ял, зэм хүртээдэг гэсэн ийм шүүмжлэл улс төрчдийн амнаас ч гэсэн удаа дараа гарсаар ирсэн. Энэ байдал дээр хуульч хүний хувьд мөн Шүүхийн ерөнхий зөвлөлийн шүүгч бус гишүүнээр ажиллах гэж байгаа хүний хувьд ямар байр суурьтай байдаг вэ. Ийм тохиолдолтой та яж тэмцэх вэ. Энэ 2 асуултыг асууя.

**Д.Амарбаясгалан:** Нэр дэвшигч Энхбаатар хариулъя.

**С.Энхбаатар:** Та бүхний энэ өглөөний амгаланг айлтган мэндчилж байна. Эрдэнэболд гишүүний асуултад хариулъя. Шүүх, Шүүхийн ерөнхий зөвлөл бол иргэдийн итгэлийг даасан байх ёстой. Эрх зүйт төрийн үндсэн зорилго бол шүүхийн хараат бус байдлыг хангах замаар хүний эрх, эрх чөлөөг хангах явдал. Энэхүү асуудлыг шийдвэрлэх гол байгууллага, түүнийг харж байдаг иргэдийн итгэл бол Шүүхийн ерөнхий зөвлөлд байдаг. Ийм учраас шүүгч хараат бус байж гагцхүү хуульд захирагдах тэр нөхцөл бололцоог хангах, Шүүхийн ерөнхий зөвлөлд очиж

ажиллах юм бол энэ бие даасан байдлыг хангах чиглэлээр хуульд заасан чиг үүргүүдийг хэрэгжүүлэх талаар бүхий л бололцоотой хүрээнд эрх хэмжээнийхээ хүрээнд ажиллах болно.

Юуны өмнө хүний эрхээ хангах, хүн төвтэй байх энэ бодлогын бичиг баримтууд батлагдаж, мөрдөгдөж байгаа. Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого дээр шүүхийн хараат бус байдал хангагдаж хариуцлагатай, иргэн төвтэй шүүхийн тогтолцоо төлөвшинө гэж заасан. Энэ хүрээнд мөн Монгол Улсын шүүх эрх мэдлийн хөгжлийн бодлогын бичиг баримт энэ 2024 онд батлагдсан. Энэ хүрээнд бас 7 зорилго, 16 зорилт бүхий бодлогын бичиг баримт батлагдаж, энэ хүрээнд шүүх эрх мэдлийн бас ойрын хугацаанд хийх ажлууд 10 жилээрээ төлөвлөгдсөн. Энэ хүрээнд бас хийх ажлууд нэлээд бий. Би мөн өөрийн хийж хэрэгжүүлж байсан ажлын хүрээнд юуны өмнө цахимжуулалттай холбоотой нээлттэй, ил тод байх асуудлыг очиж нэн түрүүнд хэрэгжүүлэх талаар өөрийн бодолтой байгаа. Шүүхийн стандарт үйлчилгээнүүдийг бий болгох, иргэд оролцогч нар тэгш эрхтэйгээр мэдээллийг авах асуудал дээр түлхүү анхаарч ажиллах болно.

2 дугаар асуудлын хувьд улс төрчид болон бусад нөлөө бүхий этгээдүүдээс шүүхийн үйл ажиллагаанд болон Шүүхийн ерөнхий зөвлөлд оролцох нөлөөлөх байдлууд дээр хэрхэн ажиллах талаар бас өөрийн үзэл бодлоо хэлье.

Тэгэхээр шүүх бол Шүүхийн ерөнхий зөвлөл нь улс төрийн нөлөө, далд хяналтаас анgid байх ёстой. Энэ бол хуулиар баталгаажсан байдаг. Хэдий тийм ч гэсэн шүүхийн бие даасан байдлыг хангах суурь нөхцөл болох эрх зүйн болон эдийн засгийн баталгаагаар хангагдах чиглэл дээр түлхүү ажиллаж, энэ тал дээр бас нэлээд оролцоотой байхыг хичээн ажиллах болно.

Шүүх бол аливаа хэргийг нөлөөн давталгүйгээр, нотолгоонд үндэслэж, хууль бус нөлөөлөл, сэтгэл хөдлөл, дарамт шахалт, сүрдүүлэг, хөндлөнгөөс оролцохоос бол үл хамаарч бие даасан байдлаар ажиллах ийм үүрэгтэй. Энэ үүргийг хэрэгжүүлэхэд хичээн ажиллах болно.

**Д.Амарбаясгалан:** Хүрэлбаатарын Баасанжаргал гишүүн асуулт асууя.

**Х.Баасанжаргал:** Манай Их Хурлынхан яг энэ албан тушаалын томилгоотой холбоотой хэд хэдэн зүйлийг цаашид анхаарахгүй бол болохгүй юм байна гэдэг асуудал яг энэ томилгоо дээр гарч ирж байгаа. Тэгэхээр би зориуд Их Хурлын гишүүдийг бас энд анхаарлаа хандуулаасай гэж хүсэж байна. Учир нь гэвэл яг энэ албан тушаал дээр нэр дэвшсэн 2 хүний материал орж ирсэн. 2 хүн нэр дэвшсэн. Гэхдээ аль аль нь бол үнэхээр шаардлага хангахуйц бол байж чадаагүй гэж би хувьдаа дүгнэж байгаа. Хуулиараа Хууль зүйн байнгын хороо буцаах тийм процесс хуулиараа байхгүй. Заавал хамгийн олон санал авсан хүнийг нь чуулганаар оруулах ийм хуультай юм билээ. Тэгэхээр хамгийн олон хүний санал авсан гээд Самдангийн Энхбаатар гээд энэ хүн өнөөдөр бол чуулганаар хэлэлцэгдэж байна гэдгийг бас бид нар 1 дүгээрт анхаарах ёстой гэж бодож байна.

2 дугаарт гэвэл энэ Шүүхийн ерөнхий зөвлөлийн шүүгч бус гишүүн, Шүүхийн ерөнхий зөвлөлийн гишүүн гэдэг бол маш өндөр хариуцлагатай албан тушаал. Тэгэхээр энэ албан тушаалын босго бол асар өндөр байх ёстой гэж би хуульч хүний хувьд бол боддог. Тэгэхээр яг ажилласан байдал, ажилласан туршлага гээд харах юм бол дандаа төрийн захиргааны байгууллага голдуу ажилласан ийм туршлага

харагдаад байгаа. Тэгэхээр би танаас ямар асуулт асуух гээд байна вэ гэвэл хуульч хүнийхээ хувьд мэргэжлийн ур чадвараа та юу гэж тодорхойлох вэ. 1 дүгээрт.

2 дугаарт шүүх эрх мэдэл шүүхийн процесс ажиллагаанд ер нь орж байсан тохиолдол танд байна уу. Ингэж орж байх явцдаа ямар асуудал дээр түлхүү анхаарахаар юм байна гэсэн ийм зүйл бодит практик дээр чинь танд байгаа юу гэдэг ийм 2 асуултыг тодруульяа.

Тэгээд манай Хууль зүйн байнгын хороо бол яалт ч үгүй л нэг хүнийг нь оруулах ёстой учраас орж ирж байгаа гэдгийг бас манай гишүүд бодолцож үзэж саналаа өгнө биз гэж хэлэх гэсэн юм.

**Д.Амарбаясгалан:** Нэр дэвшигч Энхбаатар хариульяа.

**С.Энхбаатар:** Гишүүний асуултад хариульяа. Миний хувьд МУИС-ийн Хууль зүйн сургуулийг бакалавр, магистр, Австрали Улсад олон улсын харилцааны чиглэлээр мастерын зэрэг хамгаалсан. 1999 оноос төрийн албанад яг хуулийн мэргэжилтнээс авхуулаад, хэлтсийн дарга, агентлагийн орлогч дарга, агентлагийн дарга гэсэн ийм мерит зарчмаар ажилласан. Энэ хүрээнд хууль, эрх зүйн чиглэлээр бас зөвлөгөө өгөх чиглэлийн ажлууд дээр бас оролцож, хууль боловсруулах чиглэлийн ажлуудаар орсон. Хууль зүй, дотоод хэргийн яамны харьяа агентлаг Иргэний бүртгэл мэдээллийн улсын төв, Улсын бүртгэлийн ерөнхий газар, одоо бол Архивын ерөнхий газрын даргаар ажиллаж байна. Мөн ШӨХТГ-ын орон тооны гишүүн, дэд даргаар ажиллаж байсан. Энэ үеүдэд бас энэ хууль тогтоомжийн боловсруулах, хэрэгжүүлэх, хэрэгжилтийг хангах чиглэлээр бол ажиллаж ирсэн. Мөн Хууль зүй, дотоод хэргийн сайдын эрхлэх асуудлын хүрээний 2 агентлагт ажиллаж байхдаа миний ажлын байрны тодорхойлолт дээр хуульч байх, эрх зүйч байх ийм шалгуурыг тавьсан. Энийг бол Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга, Хууль зүйн сайд 2 баталж ингэж албан тушаалын тодорхойлолтыг баталдаг. Энэ хүрээнд ингэж ажиллаж ирсэн. Хууль боловсруулах хэрэгжүүлэх чиглэлээр Улсын Их Хурал болон Засгийн газарт ажлаа тайлagnаж ингэж ирсэн.

Шүүх процесс ажиллагаатай холбоотой асуудлууд дээр гэх юм бол оюутан байхдаа би шүүхийн уртын дадлагаа бол тэнд хийж, шүүхийн анхны ойлголт авч байсан. Мөн хуулийн байгууллагуудтай тэр дундаа шүүхийн байгууллагуудтай бас ажиллаж ирсэн. 2015-2017 онд Хуулийн нөхөрлөлд, хуулийн фермд ажиллаж байсан. Энэ үед бол бас шүүхийн процесс ажиллагаануудтай танилцах, эрх зүйчийн хувиар бол зүгээр хуулийн нөхөрлөлд бол зөвлөхөөр ажиллаж, энэ үеэрээ бас энэталын асуудлууд дээр бол мэдээлэлтэй бол байж ирсэн.

**Д.Амарбаясгалан:** Хүрэлбаатарын Баасанжаргал гишүүн тодруулга.

**Х.Баасанжаргал:** Оюутан байхдаа дадлага хийсэн гэвэл энийг хуульчийн мэргэжлийн үйл ажиллагааны туршлага гэж хэлэхэд хэцүү л дээ. Тэгэхээр яг л ингээд одоо бид нар хуулиа эргэж харахгүй бол яг ийм л хүмүүс яг орж ирэх гээд байгаа байхгүй юу. Яг нэг ийм үүлэн чөлөөний нар гэдэг шиг. Тэгэхээр бид нар ийм өндөр албан тушаалд, ийм хариуцлагатай албан тушаалд дээрээс нь өнөөдөр бид нар шүүхийн нэр хүнд гээд ярьж байгаа ийм чухал нөхцөлд үнэхээр шаардлага хангасан хүнийг Их Хурлаас бол томилж явуулдаг баймаар байна. Тэгэхээр эргэж энэ хуулийн процесстий холбоотой шаардлага хангахгүй хүнийг Хууль зүйн байнгын хороо өөрөө буцаадаг байх энэ зүйлийг бас бид нар анхаарах ёстой юм байна гэж бодож байна. Тэгээд манай нэр дэвшигч ч гэсэндээ бас өөрийнхөө хариулт, зүйлийг

бас нэг тунгааж бодно биз. Ийм өндөр албан тушаал дээр би тэнцэх үү, үгүй юу гэдгээ өөрөө бас дүгнэлт хийж байгаа байх гэж найдаж байна.

**Д.Амарбаясгалан:** Амгаланбаатарын Ганбаатар гишүүн асуулт асууна.

**А.Ганбаатар:** Юуны өмнө өдрийн мэнд хүргэе гишүүддээ. Тэгээд нэр дэвшигч танд амжилт хүсье. Шүүхийн ерөнхий зөвлөл болохоор бүх шүүхийн нүүр царай болсон ийм байгууллага. Тэгээд ер нь аливаа салбар бол хүнийхээ дүрээр нийгэмд ойлгогдож байдаг. Тэгэхээр ямар хүн, ямар дүртэй, ямар имижтэй, ямар нэр хүндтэй хүн тэр салбарыг төлөөлж байна яг тэр утгаар нь бол олон нийт хүлээж авдаг. Тэгэхээр Шүүхийн ерөнхий зөвлөл бол З засаглалын нэгэн орой нь юм. Тэгэхээр энэ Баасанжаргал гишүүний мэргэжлийн хүмүүс Хууль зүйн байнгын хороо, тэр тухайн Байнгын хороод нь нэр дэвшигчээ бас чамламгүй байна шүү дээ. Тэгэхээр гишүүд маань яж сонголт хийх ёстой юм бэ. Тухайлбал энэ салбарыг сайн мэдэхгүй миний бие бол зөвхөн энэ танилцуулгыг хараад сонгоно гэхэд бол бас эргэлзээтэй.

Улс төр бизнесийн бүлэглэл энэ шүүхийн салбарт нэвчсэн, үүнээс болж нэр хүнд шүүхийн шийдвэрээс хамаарсан олон нийтэд шүүхийн нэр хүнд унаж байна гэдэг олон жилийн ийм яриа байгаа шүү дээ. Одоо бид нар бол хонгил гээд л ярьдаг. Тэгэхээр яг үнэхээр ийм бүлэглэл, фракц байдаг юм уу танай салбарт. Та энийг хэлж өгөөч.

2-т нь та нэр дэвшигчийн хувьд шүүхийн зөвлөлд ажиллахад цалин пүнлүү чинь хангалттай гэж үзэж байгаа юм уу. Ер нь шүүгч нарын цалин ер нь хангалттай байдаг юм уу. Нэгэн цагт шүүхийн зөвлөлийн дарга хэлж байсан. Тэрбум гаруй хөрөнгөтэй ийм хүн шүүгч байна гэхээр яагаад шүүгч хүн тэрбум төгрөгтэй байж болдоггүй юм бэ гэж хэлж байсан. Тэгэхээр ер нь энэ хөрөнгө орлогын хувьд бол ийм зиндааны ажил хийдэг хүмүүсийн хувьд ямар байх ёстой юм бэ. Энэ 2 дээр та хариуулж өгөөч.

Гишүүдээсээ хандаж хэлэхэд бид нар энэ дээр яг яж хандах ёстой юм. Мэргэжлийн хүмүүс нь ингэж шүүмжлээд байна шүү дээ. Тэгээд харанхуй кнопоо дарах юм уу. Энэ дээр бол яг үнэнийг хэлэхэд би бол эргэлзээтэй байгаа учраас энийг асууж байна. Буцаах процесс бол байдаггүй юм байна. Нэр дэвшээд ороод ирсэн хүнийг нь л сонгох ийм сонголт үлдэж байгаа юм байна. Тэгээд танд амжилт хүсье. Баярлалаа.

**Д.Амарбаясгалан:** Нэр дэвшигч Энхбаатар хариулт өгье. Нэмээд Хууль зүйн байнгын хорооноос бас нэр дэвшүүлэх процесстай холбоотой тайлбар өгөх нь зүйтэй байх гэж бодож байна.

**С.Энхбаатар:** Шүүх эрх мэдлийн суурь нь бол хараат бус байдал. Тэгэхээр шүүгч бол хараат бус байж, гагцхүү хуульд захирагдана. Тэгэхээр шүүх аль нэгэн, хэн нэгэн практикт хамаарагдах улс төрийн болон бусад нөлөөлөлд бол автахгүйгээр ажиллах ийм үүрэгтэй. Энэ үүргээ бол хуулийн хүрээнд хангах ёстой. Энийг Шүүхийн ерөнхий зөвлөл онцгой анхаарч ажиллах ёстой гэсэн итгэл үнэмшилтэйгээр би байдаг. Энэ чиглэлээр бас тодорхой үүрэгтэйгээр бас зорилго чиглэлтэйгээр ажиллахыг хичээх болно.

Шүүхийн цалин харьцангуй боломжийн тогтоож чадсан. Их Хурал болон Хууль зүйн байнгын хороо дээр бол энэ асуудлыг үргэлж бас дэмжиж ярьдаг. Одоо мөн

шүүхийн цалингийн асуудал, зэрэг дэвийн асуудал бол орж яригдаж байгаа. Тэгэхээр энэ бол Их Хурлын гишүүдийн та бүхний бүрэн эрхийн асуудал учраас билээ шүүхийн цалингийн асуудал дээр цалин бол боломжийн тогтоогдсон л гэж бодож хардаг.

**Д.Амарбаясгалан:** Ажлын хэсгийн ахлагч Цэндийн Сандаг-Очир гишүүн нэмэлт тайлбар өгье.

**Ц.Сандаг-Очир:** Баярлалаа. 2 гишүүний асуултад бас нэмж тайлбар хэлье. Шүүгч бус гишүүнийг сонгон шалгаруулах журам гэж байгаа. Манай ажлын хэсэг яг энэ журмын дагуу л ажилласан. Товоо тогтоосон, зараа тавьсан хэвлэл мэдээллийн байгууллагуудаар 21 хоногийн хугацаанд. Бүртгэлээ хийсэн, материал юмнуудыг цуглуулсан. Яг энэ журамд заасны дагуу процедур явсан. 2 хүн материалыа өгсөн. Энэ гишүүдийн асууж байгаа асуулт шүүгчээр ажиллаж байгаагүй туршлага байхгүй байна гэж яриад байх юм. Бид нар чинь Шүүхийн ерөнхий зөвлөлийн шүүгч бус гишүүнийг сонгон шалгаруулах гэж байгаа юм. Шүүгч бус. Шүүгчээр ажиллаж байгаагүй, прокуророор ажиллаж байгаагүй ийм хүмүүсийг одоо бид нар 50 хувьд нь шүүгч бус гишүүн байгаа. Шүүхийн ерөнхий зөвлөлийн. Энэ шүүгч бус гишүүнийг сонгон шалгаруулж байгаа гэдгээ сайн ойлгох хэрэгтэй.

**Д.Амарбаясгалан:** Сонгобайн Замира гишүүн асуулт асууж, үг хэлье.

**С.Замира:** Баярлалаа. Та бүхэнд энэ өдрийн мэндийг хүргэе. Нэгэнт Шүүхийн ерөнхий зөвлөлөөс ингээд судалгаа хийгээд явуулчихсан учраас энэ хүмүүс сонгогдох байх гээд би хувьдаа бодож байна. Тэгээд 3 асуулт байна.

1 дүгээрт Шүүхийн тамгын газар 42 байранд үйл ажиллагаа явуулж байгаагаас 36 стандартын шаардлага хангахгүй байранд, 4 шүүх нь прокурорын хамт, мөн хэдэн шүүх орон нутгийн өмчийн байранд түрээсээр байрлаж байгаа байдлыг юу гэж харж байгаа. Шүүхийн бие даасан хараат бус байдалд нөлөөлж байна уу. Энэ талаар юу гэж бодож байна.

2 дугаарт шүүхээс бусад прокурор, тагнуул, АТГ, цагдаа гэх мэт хууль хяналтын байгууллагууд хэргийн талаарх мэдээллийг хоорондоо шууд солилцдог орчин үеийн технологийн хөгжил бүхий цахим бүртгэлд холбогдсон байдаг. Шүүх хэзээ эдгээр байгууллагуудтай мэдээлэл солилцдог нэгдсэн программ хангамжтай болох вэ. Энэ талаар ямар ажил зохион байгуулах вэ.

3 дугаарт 1 шүүгч сардаа 50 хэргийг хянаж шийдвэрлэдэг. Мөн захиргааны ажилтнуудын ажлын ачаалал хэт их байгаа талаар танилцуулга дээр дурджээ. Энэ ачааллыг бодитоор бууруулах, тэдний ажиллах нөхцөлийг сайжруулахын тулд зохион байгуулалтын ямар арга хэмжээ авч ажиллах вэ гэсэн 3 асуулт байна. Баярлалаа.

**Д.Амарбаясгалан:** Нэр дэвшигч Энхбаатар хариулт өгье.

**С.Энхбаатар:** Шүүх дээр нэг чухал асуудал бол байрны хүрэлцээний асуудал байгаа. Тэгэхээр энэ асуудал дээр Улсын Их Хурал, Хууль зүйн байнгын хороо бас онцгой анхаарч Хууль зүйн байнгын хороо энэ жилийн төсөв яригдаж байх үе дээр ч гэсэн өнгөрсөн оны төсвүүд дээр ч гэсэн нэлээд яригдаж бас асуудлууд тодорхой хэмжээ дээр шийдэгдэж байгаа. Гэвч бас асуудлууд байсаар байгаа.

Шинэ хууль батлагдаж 2025 оны 1 сарын 1-ээс шүүхүүдийн тоо бас өөрчлөгдж, 117 шүүх одоо ажиллаж байгаа бол 88 шүүх болно. Энэ хүрээнд бас байрны асуудал, Дээд шүүхийн байрны асуудал бол шийдэгдэж байгаа. Энийг шат дараатайгаар зохион байгуулалтын хувьд хийх асуудлууд Шүүхийн өрөнхий зөвлөлийн баримталж байгаа тэр бодлого чиглэлийг дэмжиж ингэж ажиллана. Тойргийн шүүхүүд бас шинээр байгуулагдаж ингэж ажиллаж байгаа. Энэ зүйлүүд дээр бас өөрийн байр сууриа илэрхийлж хамтарч, дэмжиж ажиллах болно.

2 дахь асуултын хуульд мэдээлэл технологийн асуудал бол шүүхэд хэрэгжүүлэх ёстой нэн тэргүүнд хийх бололцоотой асуудлуудын нэг. Энэ жилийн тухайд бас төсөв дээр тавигдсан асуудал байна лээ. Цахимжуулалтад 9 тэрбум, түүний дотор тоног төхөөрөмжийн шинэчлэлт 5 тэрбум төгрөг тавигдсан харагдсан. Тэгэхээр энэ бол бас мэдээлэл технологийг нэвтрүүлэх цахимжуулалт дээр бас ажлууд эрчимтэй хийх ийм бололцоо тодорхой хэмжээгээр бүрдэж байна гэж ойлгож байгаа.

Тэгэхээр ил тод, нээлттэй байх, шүүхэд ирэх иргэдийн итгэлийг нэмэгдүүлэхэд бол нээлттэй шүүх байх энэ асуудал чухал. Тэгэхээр энд бол мэдээлэл технологийн ололт амжилтыг нэвтрүүлэх асуудлууд чухал байгаа. Энэ чиглэлээр бас миний бие тодорхой хэмжээнд туршлагатай, бас ажиллаж байсан. Улсын бүртгэлийн цахимжуулалт, иргэний шинэчилсэн бүртгэлийг ахалж ажиллаж байсан. Мөн манай архивын цахимжуулалт бол бас хийгдэж байгаа. Тэгээд энэ хүрээнд бас өөрийн мэдлэг туршлагыг энд зориулж ажиллана.

Дараагийн асуулт бол ажлын ачаалал зохион байгуулалтын хувьд бас 1 шүүгч дээр байх ачаалал бол өндөр. Ялангуяа анхан шатын шүүх дээр байгаа ачаалал бол өндөр харагдаж байгаа. 2023 онд харахад бол анхан шатын шүүх дээр 13.997 эрүүгийн, иргэний 63.407, захиргааны 2371 хэрэг, зөрчлийн 26.248, ингээд нийт бол 100 гаруй мянган хэрэг бол шийдвэрлэгдэж байгаа. Үүний дийлэнх нь анхан шатны шүүх дээр хэрэг шийдвэрлэгдэж байгаа асуудал байгаа. Тэгэхээр ажлын зураг авалт хийгдэж, тэнцвэртэй байдлаар шүүхийн ачааллыг хэрхэн бууруулах вэ, энд мэдээллийн технологи, цахим үйлчилгээг яаж нэвтрүүлж авах вэ зэрэг энэ асуудлыг бас .../минут дуусав/

**Д.Амарбаясгалан:** Улсын Их Хурлын гишүүд асуулт асууж, уг хэлж дууслаа.

Одоо Байнгын хорооны саналаар Самдангийн Энхбаатарыг Шүүхийн өрөнхий зөвлөлийн шүүгч бус гишүүнээр томилох саналыг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулна. Санал хураалт. 71 гишүүн буюу 73,2 хувиар санал дэмжигдлээ.

Шүүхийн өрөнхий зөвлөлийн шүүгч бус гишүүнээр томилох Хууль зүйн байнгын хорооны саналыг хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжсэн тул Шүүхийн өрөнхий зөвлөлийн шүүгч бус гишүүнээр томилох тухай Улсын Их Хурлын тогтоол батлагдсанд тооцлоо. Тогтоолыг уншиж танилцуульяа.

Монгол Улсын Их Хурлын тогтоол

Шүүхийн өрөнхий зөвлөлийн шүүгч бус бус гишүүнээр томилох тухай

Монгол Улсын шүүхийн тухай хуулийн 76 дугаар зүйлийн 76.2., 76.5 дахь хэсэг, Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1 дэх хэсэг, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 108 дугаар зүйлийн 108.3 дахь хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас тогтоох нь:

1. Самдангийн Энхбаатарыг Шүүхийн ерөнхий зөвлөлийн шүүгч бус гишүүнээр томилсугай.

2. Энэ тогтоолыг 2024 оны 12 дугаар сарын 20-ны өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

Шүүхийн ерөнхий зөвлөлийн шүүгч бус гишүүнээр томилох тухай Улсын Их Хурлын тогтоолын эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу. Алга байна. Эцсийн найруулгыг сонссонд тооцлоо.

Улсын Их Хурлаас томилогдож байгаа шүүгч бус гишүүн Самдангийн Энхбаатарт ажлын өндөр амжилтыг хүсье.

Улсын Их Хурлын Улсын Их Хурлын гишүүдийн хэлж, ярьж байгаа саналыг нэлээн анхаарч үзэж ажиллах хэрэгтэй. Цаашдаа Шүүхийн ерөнхий зөвлөл мэргэжлийн хувьд өндөр ур чадвартай, шүүхийн хараат бус байдлыг бүрэн дэмжсэн, шүүхийн үйл ажиллагаа хэвийн, хараат бусаар ажиллах тэр нөхцөл дээр онцгой анхаарч ажиллаарай гэдгийг бас захиж хэлье. Амжилт хүсье.

Ингээд өнөөдрийн нэгдсэн хуралдаанаар хэлэлцэх асуудал дуусаж байна. Ирэх 7 хоногоос эхлээд Улсын Их Хурлын чуулганаар хэлэлцэх асуудал бас нэлээдгүй ачаалал бол нэмэгдэж орж ирж байгаа. Засгийн газраас өнөөдрийн байдлаар 5 орчим хуулийн төсөл өргөн барьж байна. Ирэх 7 хоногт бас 10-аад хуулийн төсөл өргөн барихаар бэлтгэл хангагдаж байгаа. Тэгэхээр энэ 12 дугаар сарын 26, 27-ны чуулганы нэгдсэн хуралдаан, ирэх оны 1 дүгээр сарын 2, 3-ны чуулганы нэгдсэн хуралдаан бол өндөр ачаалалтай, олон асуудал хэлэлцсэн хуралдаан байна гэдгийг бас гишүүддээ мэдээлье.

Ингээд өнөөдрийн нэгдсэн хуралдаанаар хэлэлцэх асуудал дууссан тул хуралдаан өндөрлөснийг мэдэгдье.

10.33 цаг.

ДУУНЫ БИЧЛЭГЭЭС ХУРАЛДААНЫ  
ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ БУУЛГАЖ,  
ХЯНАСАН: ШИНЖЭЭЧ

Э.СУВД-ЭРДЭНЭ